БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 06 өдөр Дугаар А/237 Булган сум

Төмөрбаатарын Дэлгэрмаад сургалтад оролцоход дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны "Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай" IV/25 дугаар тогтоол, 2025 оны XII хуралдааны "Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай" XII/90 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2026 оны "Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардал батлах тухай" А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Цэнгээнт бүжгийн салбар зөвлөлийн тэргүүн Төмөрбаатарын Дэлгэрмаад "Эрүүл монгол хүн" үндэсний хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотод 2026 оны 03 дугаар сарын 23-30-ны өдрүүдэд зохион байгуулагдах Нийтийн бүжгийн спортын анхан шатны буюу мэргэшүүлэх сургалтад хамрагдахад шаардлагатай байр, хоолны зардалд 380,000 (гурван зуун наян мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын "Бүх нийтийн соёлын боловсрол олгох хөтөлбөр төлөвлөгөө"-ний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д.ГҮРЭВ-ОЧИР

6326010314